



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 6 сарын 25-ны өдөр

№ 2025/31

Улаанбаатар хот

Сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК /РД: 2001861/-тай байгуулсан 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн ЗГ/MN730052111300148592 тоот зээлийн гэрээний хугацааг 24 сараар сунгаж, Зээлийн шугамын эрхийн хэмжээг 481,720 (дөрвөн зуун наян нэг мянга долоон зуун хорь) ам.доллараар нэмэгдүүлж 1,000,000 (нэг сая) ам.доллар болгохыг зөвшөөрсүгэй.

2. Зээлийн шугамын эрхийг дараах нөхцөлөөр тогтоосугай.

Зээлийн хүү	12% /жилийн/
Комитмент хүү	0
Зээлийн хугацаа	24 сар
Ам.долларын ханш	Албан ханшаар тооцно.
Эргэн төлөх нөхцөл	Хугацааны эцэст үндсэн зээл хумих, сар бүр хүү төлөх

3. Зээлийн барьцаанд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн эзэмшлийн Ард Даатгал ХК (MSE:AIC)-ийн 5,500,000 (таван сая таван зуун мянган) ширхэг хувьцааг барьцаалж, барьцааны гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон барьцааны гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгож, зээлдэгчид зээл олголтыг хийхийг Санхүү бүртгэл эрхэлсэн захирал (Ч.Гэндэнпил) нарт тус тус даалгасугай.

5. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ